



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 10 өдөр

Дугаар Д/11

Жаргалтхаан

Э.Аранжалыг ажилд томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 56 дугаар зүйлийн 56.6 дахь заалт, Улсын Их Хурлын 2007 оны “Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 73 дугаар тогтоолын 1 дугаар хавсралт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Багийн Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаас олонхийн санал авч багийн Засаг даргад нэрийг нь дэвшүүлсэн, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4.2, 56.4.3, 56.4.4 дэхь заалтуудад заасан шаардлагыг хангасан Эрдэнэдагвын Аранжалыг Баянцогт багийн Засаг даргаар 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс үргэлжлүүлэн томилсугай.

2. Багийн Засаг даргаар томилогдсон Э.Аранжалын үндсэн цалинг 1458000 (нэг сая дөрвөн зуун тавин найман мянган) төгрөгөөр, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 30 хувь, орон нутагт ажилласны нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар тус тус тооцож цалинжуулахыг нягтлан бодогч Э.Загдхүүд зөвшөөрсүгэй.

ДАРГА

С.ГАНБАТ



Data (D:) /A4 zahiramj/